

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2009 оны
үйл ажиллагааны хяналт шинжилгээ
үнэлгээний тайлангийн 3-р хавсралт

САНАЛ АСУУЛГЫН НЭГДСЭН ДҮН

Д/д	Асуулт	/5/		/4/		/3/		/2/		/1/		Бүгд	Дундаж Үнэлгээ
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь		
1	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх таны санал дүгнэлт	326	63	201	33.6	63	2.1	8	1.3	-	-	598	3.9
2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх таны санал дүгнэлт	243	40.6	146	24.4	161	26.9	48	8.0	-	-	598	4.0
3	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх таны санал дүгнэлт	289	48.3	187	31.2	110	18.4	12	2.0	-	-	598	4.0
4	Аймгийн хэмжээнд иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний талаарх таны санал дүгнэлт	340	49.3	214	35.7	29	4.8	15	2.5	-	-	598	4.2
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ												4.03	

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ

Хэрэглэгчийн үнэлгээ буюу санал асуулгын нэгдсэн дүнгийн талаар:

Монгол Улсын Засгийн газрын болон аймаг, орон нутгаас хэрэгжүүлж байгаа бодлого, шийдвэрүүд ард иргэдийн амьдрал ахуйд хэрхэн үр өгөөжөө өгч байгаа, цаашид засч сайжруулах ямар ажил, асуудлууд байгааг тодотгож, нэгдсэн мэдээлэл цуглуулах зорилгоор дээрх 4 чиглэлийн 5 боломжит хувилбартай хариулттай санал асуулгыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тухайн бүс орон нутагт идэвхтэй, байнга үйл ажиллагаа явуулдаг зарим төрийн бус байгууллага, томоохон аж ахуйн нэгжийн төлөөллийг багтаасан ажлын хэсгээр гүйцэтгүүлсэн.

Тус ажлын хэсэг буюу судалгааны баг нь хүн амын төвлөрөл ихтэй худалдаа үйлчилгээний цэг, үзвэр, үйлчилгээний газруудаар үйлчлүүлж байгаа иргэдийн төлөөллөөс авч үр дүнг асуулга бүрээр нэгтгэн тооцсон.

Дээрх 4 асуултаас аймгийн хэмжээнд иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний талаарх таны асуултад иргэд өндөр оноо өгсөн дүн гарч байгаа нь сүүлийн 2 жилд аймгийн Засаг даргын Тамгын газраас аймгийн төвд байрладаг 16 төрийн үйлчилгээг алслагдсан сумын ард иргэдэд хүрч үйлчлэх боломжийг хангаж сум бүхэнд хугацаа, хуваарийн дагуу зохион байгуулж байгаа “Аймгийн нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээ нь иргэдийн сэтгэл санаанд нийцсэн оновчтой арга хэмжээ болж байгаагийн илрэл гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Зарим сумдад зохион байгуулагдсан аймгийн Засаг даргын нэрэмжит иж бүрэн үзлэг, шалгалтын үеэр тухайн орон нутаг, тэнд ажиллаж амьдарч байгаа иргэдээс тусгайлан бэлтгэсэн санал асуулгыг авч үр дүнг нь үзлэгийн нэгдсэн дүнгийн хурлын үеэр аймаг, сумын удирдлагууд, төрийн албан хаагчид, ард иргэдийн төлөөллийг байлцуулан хэлэлцэж, цаашид хэрхэн ажиллах ажлын төлөвлөгөө, чиглэлээ тодорхойлж, хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх зэрэг асуудлуудыг тухай бүр зохион байгуулж ажиллалаа.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР